



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/54

Мөрөн сум

Төсөвт өртгийн дээд хязгаар  
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ээлжит XXIII хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан дахь “Зураг төсвийн сангийн шилжих хөрөнгө оруулалт”-аар санхүүжүүлэх барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээнд зарцуулах төсөвт өртгийн дээд хязгаарыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад дурдсан 12 төсөл арга хэмжээний зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний санхүүжилтэд шаардлагатай 256,757,000 (Хоёр зуун тавин зургаан сая долоон зуун тавин долоон мянга) төгрөгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шилжих зураг төсвийн сангаас гаргаж зарцуулахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ





Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар  
сарын 08-ны өдрийн А/.....дугаар  
захирамжийн хавсралт

АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН ДАХЬ “ЗУРАГ ТӨСВИЙН САН ШИЛЖИХ”-ЭЭС  
САНХҮҮЖҮҮЛЭХ ШИНЭЭР БАРИХ, ЗАСВАРЛАХ, ШИНЭЧЛЭХ, БАРИЛГА  
БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ТӨЛБӨРИЙН ТӨСӨВТ ӨРТГИЙН ДЭЭД ХЯЗГААР

№	Арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Тайлбар
1	“Иргэдэд төрийн үйлчилгээг нэг цэгээс түргэн шуурхай хүргэх, төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-ийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах	18,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
2	Алаг-Эрдэнэ сумын Хатгал тосгоны 15 ортой эрүүл мэндийн төвийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах	32,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
3	Мөрөн сумын 5 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилгын ажил	24,900,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
4	Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын барилгын инженер геологийн судалгаа	3,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
5	Галт сумын Засаг даргын Тамгын газрын барилгын инженер геологийн судалгаа	3,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
6	Галт сумын дотуур байрын барилгын инженер геологийн судалгаа	3,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
7	"Сод эрдэм" сургуулийн баруун талын хатуу хучилттай авто замын төгсгөлөөс: 1.1 тойрог үүсгэн MSC-ын агуулахын урд талын 3 замын уулзвар хүртэлх авто зам, 1.2 Мөрөн сумын төвлөрсөн хог хаягдлын цэгийн хяналтын пүү хүрэх авто зам. 2.	55,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна



	Тухайн тойрог замын хэвтээ тэнхлэгийн дагуух холбоос замуудын ажлын зураг төсөл боловсруулах		
8	“Ханх сумын 480-н хүүхдийн сургуулийн барилга”-ын ажлын зураг төсөл боловсруулах	55,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
9	Цахилгааны хангамжийг сайжруулж 15/0.4кВт дэд станц барих, 0.4 кВт-ын шугам шинэчлэх /Улаан-Уул сум/ ажлын зураг төсөл	7,500,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
10	Сумын төвийн хогийн цэгийг дарж булшлах ажлын /Тариалан сум/	17,157,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
11	Гал түймэр унтраах, аврах ангийн барилгын ажлын зураг төсөл боловсруулах /Тариалан сум/	35,000,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
12	Мөрөн сумын хог хаягдлын цэг дэх ажилтны амрах бйрны барилгын ажлын зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээ худалдан авах	3,200,000	Холбогдох хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичигт заасан шаардлагыг хангасан байна
	НИЙТ ДҮН	256,757,000	